



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/91

Улаанбаатар хот

Г Журам шинэчлэн батлах тухай Г

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэхь хэсэг, Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”, Засгийн газрын 2014 оны “Дүрэм, журам батлах тухай” 354 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм” 3 дугаар зүйлийн 3.1.8, 3.1.10-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нийгмийн даатгалын ерөнхий газрын шагнал олгох, дээд шатны байгууллагын шагналын тодорхойлолт хүлээн авч шийдвэрлүүлэх журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Б.Батсүх/-т даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2010 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 89 дүгээр тушаал, 2012 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 380 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА

Д.ЗОРИГТ

Нийгмийн даатгалын ерөнхий газрын
даргын 2022 оны 05 дүгээр сарын
31-ны өдрийн А/Б.1 тоот тушаалын
хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ШАГНАЛ ОЛГОХ, ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГЫН ШАГНАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ ХҮЛЭЭН АВЧ ШИЙДВЭРЛҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, нийгмийн даатгалын сангийн хуримтлалыг нэмэгдүүлэх, салбарын хүрээнд дэвшүүлж буй зорилтуудыг хэрэгжүүлэх ажилдаа идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилтнуудын амжилт бүтээлийг үнэлэн, урамшуулан шагнал олгож болно.
- 1.2 Нийгмийн даатгалын ерөнхий газрын шагнал нь дараах төрөлтэй байна.
- а/ Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Жуух бичиг”
 - б/ Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Хүндэт ажилтан” цол тэмдэг
- 1.3 Хамтран ажилладаг байгууллагын ажилтан, албан хаагчдыг шагналд шагнуулахаар тодорхойлж болно.

ХОЁР. ШАГНАЛ ОЛГОХ НӨХЦӨЛ

- 2.1 Тухайн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн нийгмийн даатгалын байгууллагад 5 ба түүнээс дээш жил үр бүтээлтэй, санаачилгатай, алдаа дутагдалгүй ажилласан ажилтанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Жуух бичиг” олгоно.
- 2.2 Нийтдээ 8-аас доошгүй жил үр бүтээлтэй, санаачлагатай, ажилласан ажилтныг Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Хүндэт ажилтан” цол тэмдгээр шагнаж болно.
- 2.3 Шагнуулахаар уламжилсан албан хаагчдын холбогдох материалыг эх хувиар нь шагналд тодорхойлж буй байгууллага нь бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:
- 1. Шагнуулах хүний анкет
 - 2. Ажил байдлын тодорхойлолт (байгууллагын дарга гарын үсэг зурж баталгаажуулсан байна.)
 - 3. Хамт олны хурлын тэмдэглэл
 - 4. Шагналын хуулбар (сүүлд авсан)
- 2.4 Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны өдөр, Шинэ жил, Цагаан сар, болон Үндэсний их баяр наадмын тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан шагналыг олгоно.

- 2.5 Шаггалын материалыг тэмдэглэлт өдөр болохоос 1 сарын өмнө Нийгмийн даатгалын ерөнхий газарт эх хувиар нь ирүүлсэн байна.
- 2.6 Шагнал авах нөхцөлд дурдсан ажилласан жилийг хангаагүй, хугацаанаас хоцорсон болон дутуу материал ирүүлсэн тохиолдолд шагнал олгогдохгүй ба дутуу материалыг эргүүлэн өгөхгүй.
- 2.7 Нийгмийн даатгалын газар, хэлтсүүд нийт ажилчдын шагналын мэдээллийн сантай болж, шагналыг давхардуулахгүй, алгасаж олгохгүй байх тал дээр бүртгэл хөтлөн ажиллана.
- 2.8 Шагналд мөнгөн шагнал дагалдахгүй.

ГУРАВ. ДЭЭД ШАТНЫ ШАГНАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ ХҮЛЭЭН АВАХ, ШИЙДВЭРЛҮҮЛЭХ

- 3.1 Нийгмийн даатгалын газар, хэлтсүүд олон жил үр бүтээлтэй ажилласан ажилтныг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны болон бусад яамны шагналаар шагнуулахаар материалыг бүрдүүлэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт ирүүлж болно.
- 3.2 Тухайн салбарын болзол, шаардлага хангасан материалыг тэмдэглэлт өдрөөс 2 сарын өмнө ирүүлэх бөгөөд материалыг Нийгмийн даатгалын ерөнхий газар судлан Хөдөлмөр, нийгмийн хамгааллийн яам болон бусад яаманд уламжилна.
- 3.3 Салбарын яамны шагнал авсан ажилтныг төрийн дээд одон медаль олгуулахаар тодорхойлж, холбогдох материалыг “Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”-ын дагуу бүрдүүлэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт ирүүлнэ. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь ирсэн саналыг дээд шатны байгууллагад зохих журмын дагуу хүргүүлнэ.

